



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2024 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1 дэх заалт, 24.6 дахь хэсэг, Монгол улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Япон сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл"-ийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй батлуулсугай.

Зөвлөлийн дарга	Б.Мөнх-Эрдэнэ	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга
	Э.Хишигбуян	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн төсөл хөтөлбөр, судалгаа, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
	М.Амаржаргал	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
	Б.Батсайхан	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Санхүү бүртгэлийн албаны нярав
Нарийн бичгийн дарга	Б.Батцэцэг	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төслийн Санхүүгийн мэргэжилтэн

2. Байгууллагын үндсэн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон зайлшгүй шаардлагатай эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах

асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасугай.

3.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллан, үр дүнг танилцуулж байхыг Өмч хамгаалах байнгын зөвлөл (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАЛЫН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

